



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 81/79

Улаанбаатар хот

Б.Төвшинтөрд сахилгын
шийтгэл ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13, 48 дугаар зүйлийн 48.1.2, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам"-ын 1.3.1, 1.3.3, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны А/1716 дугаар тушаалаар батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 10.1, 10.4, 10.5, 10.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Баярсайханы Төвшинтөр албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хангалтгүй биелүүлсэн нь дотоод хяналт шалгалт болон өөрийн гаргасан тайлбараар тогтоогдсон тул түүнд 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс "Нийт ажилтанд зарлах хэлбэрээр нээлттэй сануулах" сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Өдөр тутмын үйл ажиллагаандаа хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо хэрэгжүүлж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг улсын бүртгэгч Б.Төвшинтөрд үүрэг болгосугай.

3.Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахин ажиллахыг анхааруулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс (П.Мөнхбаатар)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар (Д.Давааням)-т тус тус үүрэг болгосугай.

4.Энэ тушаалыг эс зөвшөөрвөл улсын бүртгэгч Б.Төвшинтөрд тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор Төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



У.БОЛДХҮҮ

142500508